

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5-6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7-8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9-10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12-13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль,эрх зүй.....	14-15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого,дотоод хяналт.....	14-15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15-16
3.6 Төсвийн төлөвлөлт,гүйцэтгэл.....	16-17
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	17-18
3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17-18
3.9 Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18-19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	18
3.10 Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	18-19
4. Аудитаар илэрсэн алдаа,зөрчлийн жагсаалт.....	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ЗАХИРАГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.АМАРЖАРГАЛ
ТАНАА

2021.02.25 № 07/586
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллага олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан “Чөлөөт бүсийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, чөлөөт бүсэд баригдаж байгаа барилга байгууламжид Барилгын тухай хуулийн дагуу хяналт тавих, бүсийн цахилгааны хязгаарлалтад хамрагдах, зам талбайн аюулгүй байдлыг хангах, зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эмх цэгцтэй байдлыг хангах” гэсэн ажлыг бусад мэргэжлийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр хамтран хийх төлөвлөгөө боловсруулан шийдэх ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох

бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхийн аудитын тайлан гаргах үүрэгтэй.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>893,956,700.55</u>	<u>501,766,420.16</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	72,200,058.00	72,200,058.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	72,200,058.00	72,200,058.00
3121	Төгрөг	72,200,058.00	72,200,058.00
31211	Төрийн сангийн харилцах	72,200,058.00	72,200,058.00
33	АВЛАГА	809,899,027.12	423,999,179.12
335	Бусад авлага	809,899,027.12	423,999,179.12
3351	Байгууллагаас авах авлага	809,899,027.12	423,999,179.12
35	БАРАА МАТЕРИАЛ	11,857,615.43	5,567,183.04
354	Хангамжийн материал	11,857,615.43	5,567,183.04
35410	Бичиг хэргийн материал	204,600.00	233,915.00
35440	Түлш, шатах тослох материал	255,055.28	440,363.55
35470	Бусад хангамжийн материал	11,397,960.15	4,892,904.49
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>23,197,352,828.46</u>	<u>22,201,043,296.14</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	23,197,352,828.46	22,201,043,296.14
392	Биет хөрөнгө	18,015,066,461.68	17,029,122,929.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	18,937,197,627.64	19,144,924,971.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,556,253,984.76)	(2,448,073,882.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,000,000.00	5,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,000,000.00)	(1,437,499.98)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	387,804,621.62	358,598,320.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(133,302,998.59)	(145,664,045.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,053,044.85	59,629,116.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(62,497,814.08)	(36,818,518.13)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	357,065,965.00	92,214,467.00
393	Биет бус хөрөнгө	5,182,286,366.78	5,171,920,366.82
39301	Програм хангамж	3,700,000.00	3,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,033,333.22)	(2,733,333.18)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,430,982,200.00	5,422,966,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(250,362,500.00)	(252,012,500.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>24,091,309,529.01</u>	<u>22,702,809,716.30</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>72,364,137.00</u>	<u>72,200,058.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	72,364,137.00	72,200,058.00
413	Өглөг	72,364,137.00	72,200,058.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	164,079.00	0.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	72,200,058.00	72,200,058.00
4136	Бусад өглөг	0.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	0.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>24,018,945,392.01</u>	<u>22,630,609,658.30</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	24,018,945,392.01	22,630,609,658.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,542,753,318.00	6,542,753,318.00
51101	Өмч: - төрийн	6,542,753,318.00	6,542,753,318.00
512	Хуримтлагдсан үр дүн	17,155,111,111.07	15,775,034,726.22
51210	Өмнөх үеийн үр дүн	18,568,839,640.99	17,163,370,459.93
51220	Тайлант үеийн үр дүн	(1,413,728,529.92)	(1,388,335,733.71)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	321,080,962.94	312,821,614.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>24,091,309,529.01</u>	<u>22,702,809,716.30</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	752,986,140.50	1,014,796,706.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,884,740.50	315,104,606.66
120	Нийтлэг татварын бус орлого	112,884,740.50	1315,104,606.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	112,884,740.50	80,265,918.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	112,884,740.50	80,265,918.00
120009	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	0.00	234,838,688.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	640,101,400.00	699,692,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	640,101,400.00	699,692,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	640,101,400.00	699,692,100.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	0.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,834,903,900.42	1,758,283,394.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,834,903,900.42	1,758,283,394.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,578,100,758.84	1,609,562,719.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	392,768,312.50	470,114,581.00
210101	Үндсэн цалин	363,748,312.50	440,625,581.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,020,000.00	29,489,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,395,948.60	58,948,388.29
210201	Тэтгэврийн даатгал	34,557,107.66	41,225,006.93
210202	Тэтгэмжийн даатгал	4,065,541.80	4,850,000.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,129,553.39	3,752,320.66
210204	Ажилгүйдлийн даатгал	694,888.07	829,187.81
210205	Эрүүл мэндийн даатгал	6,948,857.68	8,291,872.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,753,502.00	66,346,392.00
210301	Гэрэл, цахилгаан	55,890,800.00	55,621,370.00
210302	Түлш, халаалт	6,612,702.00	6,475,022.00
210303	Цэвэр, бохир ус	4,250,000.00	4,250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,513,622.36	15,075,810.54
210401	Бичиг хэрэг	2,430,290.00	2,896,654.00
210402	Тээвэр, шатахуун	4,864,595.54	3,583,291.73
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,018,736.82	1,630,809.15
210404	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	6,765,055.66
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,920,308.00	2,830,000.00
210604	Урсгал засвар	12,920,308.00	2,830,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,906,280.00	0.00
210702	Дотоод албан томилолт	2,906,280.00	0.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,149,886.50	42,270,825.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,281,920.00	35,353,901.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	306,504.00	306,504.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,700.00	197,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,938,800.00	1,520,520.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,398,962.50	892,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	997,692,898.88	954,276,722.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	770,000.00	460,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	996,922,898.88	953,516,722.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	256,803,141.58	148,720,674.56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	800,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	254,703,141.58	147,920,674.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	254,703,141.58	147,920,674.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(1,081,917,759.92)</u>	<u>(743,486,687.71)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	331,810,770.00	644,849,046.00
225002	Найдваргүй авлагын алдагдал	331,810,770.00	367,217,548.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	277,631,498.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(331,810,770.00)	(644,849,046.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(1,413,728,529.92)</u>	<u>(1,388,335,733.71)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>786,983,297.00</u>	<u>798,640,318.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	146,881,897.00	98,948,218.00
120	Нийтлэг татварын бус орлого	146,881,897.00	98,948,218.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	146,881,897.00	98,948,218.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	146,881,897.00	98,948,218.00
120009	Бусад орлого	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	640,101,400.00	699,692,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	640,101,400.00	699,692,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	640,101,400.00	699,692,100.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>839,521,824.00</u>	<u>798,640,318.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	839,521,824.00	<u>798,640,318.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	582,718,682.42	649,919,643.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	392,594,643.39	470,413,921.87
210101	Үндсэн цалин	290,446,666.39	332,348,225.07
210102	Нэмэгдэл	73,283,977.00	105,511,448.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,864,000.00	32,554,248.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,405,538.71	58,813,126.42
210201	Тэтгэврийн даатгал	34,558,706.18	41,133,029.58
210202	Тэтгэмжийн даатгал	4,063,941.80	4,839,179.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,132,113.48	3,743,663.79
210204	Ажилгүйдлийн даатгал	695,525.15	827,023.07
210205	Эрүүл мэндийн даатгал	6,955,252.10	8,270,230.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,753,502.00	66,346,392.00
210301	Гэрэл, цахилгаан	55,890,800.00	55,621,370.00
210302	Түлш, халаалт	6,612,702.00	6,475,022.00
210303	Цэвэр, бохир ус	4,250,000.00	4,250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,647,126.82	7,354,544.15
210401	Бичиг хэрэг	2,344,590.00	1,755,135.00
210402	Тээвэр, шатахуун	5,083,800.00	3,768,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,018,736.82	1,630,809.15
210404	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,223,805.00	2,830,000.00
210604	Урсгал засвар	14,223,805.00	2,830,000.00

2107	Томилолт, зочны зардал	2,906,280.00	0.00
210702	Дотоод албан томилолт	2,906,280.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,417,786.50	43,701,659.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,439,820.00	35,234,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	306,504.00	306,504.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,700.00	197,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,938,800.00	2,326,520.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,508,962.50	1,636,635.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	770,000.00	460,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	770,000.00	460,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	256,803,141.58	148,720,674.56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	800,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	254,703,141.58	147,920,674.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	254,703,141.58	147,920,674.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(52,538,527.00)</u>	<u>0.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,200,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,200,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,200,000.00	0.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	0.00
223001	Бусад хөрөнгө	1,200,000.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,200,000.00)</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(53,738,527.00)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	125,938,585.00	72,200,058.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	72,200,058.00	72,200,058.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	6,542,753,318.00	321,080,962.94	18,568,839,640.99	25,432,673,921.93
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(1,413,728,529.92)	(1,413,728,529.92)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,542,753,318.00	321,080,962.94	17,155,111,111.07	24,018,945,392.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	8,259,348.86	8,259,348.86
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,	0.00	(8,259,348.86)	0.00	(8,259,348.86)
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(1,388,335,733.71)	(1,388,335,733.71)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,542,753,318.00	312,821,614.08	15,775,034,726.22	22,630,609,658.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	699,692,100.00	650,719,643.44	48,972,456.56	93.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	699,692,100.00	650,719,643.44	48,972,456.56	93.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	698,831,100.00	649,919,643.44	48,911,456.56	93.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	508,025,100.00	470,413,921.87	37,611,178.13	92.6
210101	Үндсэн цалин	367,302,800.00	332,348,225.07	34,954,574.93	90.5
210102	Нэмэгдэл	105,504,000.00	105,511,448.00	(7,448.00)	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,218,300.00	32,554,248.80	2,664,051.20	92.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,583,400.00	58,813,126.42	9,770,273.58	85.8
210201	Тэтгэврийн даатгал	48,262,400.00	41,133,029.58	7,129,370.42	85.2
210202	Тэтгэмжийн даатгал	5,080,300.00	4,839,179.84	241,120.16	95.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,064,200.00	3,743,663.79	320,536.21	92.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,016,100.00	827,023.07	189,076.93	81.4
210205	Эрүүл мэндийн даатгал	10,160,400.00	8,270,230.14	1,890,169.86	81.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,170,000.00	66,346,392.00	823,608.00	98.7
210301	Гэрэл, цахилгаан	55,890,800.00	55,621,370.00	269,430.00	99.5
210302	Түлш, халаалт	7,026,000.00	6,475,022.00	550,978.00	92.2
210303	Цэвэр, бохир ус	4,253,200.00	4,250,000.00	3,200.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	7,355,700.00	7,354,544.15	1,155.85	100.0
210401	Бичиг хэрэг	1,755,300.00	1,755,135.00	165.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,768,900.00	3,768,600.00	300.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,631,500.00	1,630,809.15	690.85	100.0
210404	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,830,000.00	2,830,000.00	0.00	100.0
210601	Урсгал засвар	2,830,000.00	2,830,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00	0.00	0.0
210702	Дотоод албан томилолт	0.00	0.00	0.00	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,372,500.00	43,701,659.00	670,841.00	98.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,243,900.00	35,234,900.00	9,000.00	99.9

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	356,000.00	306,504.00	49,496.00	86.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	538,600.00	197,100.00	341,500.00	36.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,700.00	0.00	32,700.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,334,900.00	2,326,520.00	8,380.00	99.6
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,866,400.00	1,636,635.00	229,765.00	87.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	494,400.00	460,000.00	34,400.00	93.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	494,400.00	460,000.00	34,400.00	93.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	861,000.00	800,000.00	61,000.00	92.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	861,000.00	800,000.00	61,000.00	92.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	861,000.00	800,000.00	61,000.00	92.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	699,692,100.00	749,667,861.44	49,975,761.44	107.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	699,692,100.00	650,719,643.44	48,972,456.56	93.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	699,692,100.00	650,719,643.44	48,972,456.56	93.0
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.00	98,948,218.00	- 98,948,218.00	0.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	98,948,218.00	- 98,948,218.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	72,200,058.00	- 72,200,058.00	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	72,200,058.00	- 72,200,058.00	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42	35	7	83.3
620001	Удирдах ажилтан	2	2	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	28	21	5	75.0
620003	Үйлчлэх ажилтан	12	12	0	100.0

3. Аудитын тайлан

1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Амаржаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээлэлийг хугацаанд нь оруулах, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Стандарт дүгнэлт аудит ХХК-ийн чанарын менежер Б.Наранцэцэг, аудитор А.Цэрэнчимэд, аудиторын туслах Ч.Мөнхбулган нар хариуцаж хэрэгжүүлэв.

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 1 сарын 15-ний өдрийн 01/30 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, хасах
- Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдэд газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох
- Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах эрүүл мэндийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу олгох

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус газрын дотоод хяналтын мэргэжилтэн 2020 онд харьяа газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 956,574.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,565.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг, гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,388,499.7 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	72,200.1	72,200.1	0.00
Авлага	809,899.0	423,999.2	(385,899.8)
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	11,857.6	5,567.2	(6,290.4)
Үндсэн хөрөнгө	23,197,352.8	22,201,043.3	(996,309.5)
Нийт хөрөнгө	24,091,309.5	22,702,809.8	(1,388,499.7)
Өр төлбөр	72,364.1	72,200.1	(164.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	24,018,945.4	22,630,609.7	(1,388,335.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	24,091,309.5	22,702,809.8	(1,388,499.7)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 72,200.1 мянган төгрөг нь төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээс байршуулсан гүйцэтгэлийн баталгаа байна.

Авлага дансны үлдэгдэл 385,899.8 мянган төгрөгөөр буурсан нь газар эзэмших гэрээтэй байсан 12 байгууллагын 367,217.5 мянган төгрөгийн газрын төлбөрийн авлагыг Нийслэл, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019, 2020 оны шийдвэрийг үндэслэн тус бүсийн захирагчийн 2020 оны А/78, А/101 дугаар захирамжаар хэрэгсэхгүй болгож найдваргүй авлагын алдагдлаар бүртгэсэн, 18,682.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулсантай тус тус холбоотой байна. Авлага дансны үлдэгдэлд 2008-2015 онуудад үүссэн, 5-аас дээш жил болсон 287,106.7 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 199,474.0 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь чөлөөт бүсийн газар дээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл нь цуцлагдаж үйл ажиллагаа нь зогссон байгууллагын газрын төлбөрийн авлага байна. Тус алба нь дээрх

авлагыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагад хандан нэхэмжлэл гаргуулан ажиллаж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5,567.2 мянган төгрөг болж 6,290.4 мянган төгрөгөөр буурсан нь 2020 онд Захирагчийн 2020 оны А/04 дүгээр захирамжаар 6,765.1 мянган төгрөгийн бараа материал акталсан нь шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант хугацааны эцэст 22,201,043.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 996,309.5 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь үндсэн хөрөнгийн дараах орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой байна. Үүнд:

- Орлого: “Шинэ-Үндэс” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар баригдсан 264,851.5 мянган төгрөгийн конторын барилга, 4,764.0 мянган төгрөгийн газрыг шилжүүлэн авсан.
- Зарлага: ТӨБЗГ-ын 2020 оны А-1/135 дугаар тогтоолыг үндэслэн 12,032.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, эд хогшил акталсан
- Засгийн Газрын “Барилга хүлээн авах, дуусаагүй барилга шилжүүлэх тухай” 2020 оны 3 дугаар сарын 104 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын “Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 2020 оны 9 дүгээр сарын 451 дүгээр тогтоолыг үндэслэн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан 207,727.3 мянган төгрөгийн дуусаагүй барилга, 12,780.0 мянган төгрөгийн газрыг бусдад шилжүүлж данснаас хассан.

Өр төлбөр дансны үлдэгдэл 72,200.1 мянган төгрөг болж 164.0 мянган төгрөгөөр буурсан нь ажилчидтай холбоотой өглөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн 72,200.1 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө байна.

Засгийн Газрын оролцоо дансны үлдэгдэл 22,630,609.7 мянган төгрөг болж 1,388,335.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны орлого үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь үйл ажиллагааны зардал, үндсэн хөрөнгө худалдсаны гарз, найдваргүй авлагын алдагдлаас шалтгаалсан байна.

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 261,810.6 мянган төгрөгөөр буюу 34.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь Засгийн Газар, ТӨБЗГ-ын шийдвэрээр үнэ төлбөргүй биет болон биет бус үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан байна.

Нийт зардал өмнөх оноос 76,620.6 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал засвар, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 8,259.3 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь ТӨБЗГ-ын 2020 оны 3 дугаар сарын 10-ны “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 60 дугаар тогтоолыг үндэслэн хийсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 721,668.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 21,976.0 мянган төгрөгөөр бууруулж 699,692.1 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөл болон өмнөх оны баталсан төсвөөс материаллаг өөрчлөлт байхгүй байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 699,692.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 98,948.2 мянган төгрөг, нийт 798,640.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 649,919.6 мянган төгрөгийг зарцуулж 147,920.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 649,919.6 мянган төгрөг буюу 93.0 хувьтай байгаа нь цалинтай холбоотой зардлыг 47,381.5 мянган төгрөгөөр, бусад зардлыг 1,230.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь батлагдсан орон тоо 7 хүнээр дутуу байгаа нь цалинтай холбоотой зардал хэмнэлттэй гарахад нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдса “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 161 мэдээллээс хугацаандаа оруулсан 151 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт 21,976.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,898.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,898.1	1	3,898.1			100.0
Албан шаардлага	1	0.00	1	0.00			100.0
Зөвлөмж	2	0.00	2	0.00			100.0
Нийт дүн	4	3,898.1	4	3,898.1			100.0

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 53,824.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 53,824.9 мянган төгрөгийн алдааг залруулж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх 2 албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайлан дахь мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг 53,738.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг мөнгөн гүйлгээний тайланд залруулга хийв.
2. ТӨБЗГ-ын Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай 2020 оны 3 дугаар сарын 10-ны 60 дугаар тогтоолоор батлагдсан үнийг шинэчлэн тогтоосон үндсэн хөрөнгийн гүйлгээг 86.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг санхүүгийн тайлангийн тодруулга дахь үндсэн хөрөнгийн тайланд залруулга хийв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, дотоод хяналтыг хэрэгжүүлэх 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудитаар 9 мэдээлэл хугацаа хоцроосон, 1 мэдээлэл байршуулаагүй зөрчил илэрсэн.* Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан хүлээнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2. Дотоод хяналтын мэргэжилтэн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Цаашид аж ахуйн нэгж байгууллагын газрын төлбөрийг барагдуулах ажлыг эрчимжүүлж авлагыг бууруулах, чөлөөт бүсийн ашиглагдаагүй газрыг аж ахуйн нэгжид эзэмшүүлэн үйл ажиллагааг нь дэмжих ажлыг эрчимжүүлэх ажлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.2.12			САГ-2021/317/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Дотоод хяналтын мэргэжилтэн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгээгүй байна	0.00	Албан шаардлага	Захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Амаржаргал Г.Балцэцэг
2	Шилэн дансны мэдээлэлээс 9 мэдээлэл хугацаа хоцроосон, 1 мэдээлэл байршуулаагүй.	0.00	Албан шаардлага	Захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ерөнхий нягтлан бодогч	Ж.Амаржаргал Г.Балцэцэг
	ДҮН	0.00			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 213/АД160059
САТ-2021/317/СТА-тцз

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим мэдээлэлд оруулбал зохих 161 мэдээллээс 9 мэдээллийг хугацаа хоцроож, 21,976.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудитаар 9 мэдээлэл хугацаа хоцроосон, 1 мэдээлэл байршуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт"-ийг долоо хоногийн дотор, 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр гүйлгээний утга, хүлээн авагчийн нэр"-ийг тухай бүр нь мэдээлнэ гэсэн заалтууд, 7 дугаар зүйлийн 7.1.3-т "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан хүлээнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Амаржаргал, ерөнхий нягтлан бодогч Г.Балцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Р.ЦОЛМОН

А.ЦЭРЭНЧИМЭД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban Shardlaga\2021\0225auditin 2-R Gazar206.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 214/A0160058

Улаанбаатар хот

СМ- 2021/317/СТА-ПМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны дотоод хяналтын мэргэжилтэн санхүүгийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дотоод хяналтыг сайжруулан байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны захирагч Ж.Амаржаргал, ерөнхий нягтлан бодогч Г.Балцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:


АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР
СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Р.ЦОЛМОН

А.ЦЭРЭНЧИМЭД



[illegible]

[illegible]